

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ, МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ

1999 оны сар 1-д өдөр

Дугаар А/113, А-71

Улаанбаатар хот.

Тогтоол хэрэгжүүлэх тухай.

1. Монгол Улсын Засгийн Газрын 1999 оны 72 дугаар тогтоолыг үндэслэн Нийслэлийн Түргэн тусламжийн төв, Түргэн тусламжийн автобаазыг нэгтгэн “Яаралтай тусламжийн төв” болгон зохион байгуулсугай.

2. Яаралтай тусламжийн төвийн захирлаар Гончигийн Цулбуурыг 1999 оны 5 дүгээр сарын 1-ний өдрөөс томилсугай.

3. Төвийн бүтэц зохион байгуулалт, дүрмийг боловсруулж Нийслэлийн эрүүл мэндийн газраар батлуулахыг Яаралтай тусламжийн төвийн захирал (Г.Цулбуур)-д даалгасугай.

4. Яаралтай тусламжийн төвийг өөрчлөн зохион байгуулах, ажил хүлээлцүүлэх комиссыг хавсралтын ёсоор баталж, шинэ бүтэц, зохион байгуулалт, хүн хүч, санхүү, хангамж үйлчилгээний нэгдмэл үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг бүрэн хийж дуусгаж, дүнг танилцуулахыг комиссын дарга (Ё.Тэрбиш)-д үүрэг болгосугай.

5. Энэ тушаал, захирамж гарсантай холбогдуулан Монгол Улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Нийслэлийн Засаг даргын 1996 оны А/176\186 тоот хамтарсан тушаал, захирамжийн 2 дугаар заалтыг хүчингүй болгосугай.


ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

С.СОНИН

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

ЭМНХ-ын сайд, Нийслэлийн Засаг Даргын 1999 оны
 А/Н/З, А/Т/Оот хамтарсан тушаал, захирамжийн хавсралт.



**Яаралтай тусламжийн төвийг өөрчлөн зохион байгуулах,
 ажил хүлээлцүүлэх комисс**

Комиссын дарга: Ё.Тэрбиш, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Жү.Энхбаяр, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Мэргэжилтэн

Гишүүд:
 Г.Цэцэгдарь, тус яамны СУТГ-ын мэргэжилтэн
 Ш.Нямсүрэн, тус яамны ТЗУГ-ын мэргэжилтэн
 А.Мөнхжаргал, тус яамны МХШҮГ-ын мэргэжилтэн
 Д.Лодой, ЭМНХЯ-ны БХЗГазрын мэргэжилтэн
 Б.Баасандорж, Нийслэлийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн
 Н.Оюун, ТӨХ-ны мэргэжилтэн